

ОН ЖИЛҮҮДИЙН УРСГАЛД (проф. А.Пэрлээтэй хийсэн ярилцлага)

Н.Одгэрэл
МУИС-ийн Геологийн салбар



30 жилийн өмнөх залуу
эрдэмтэн А.Пэрлээ

Монгол улсад үндэсний геологч мэргэжилтэн бэлтгэжэхэлснээс хойш эдүгээ 50 жил өнгөрчээ. Энэ үндэсний геологийн мэргэжилтнүүд нь геологийн салбарын нэр хүндийг гадаад дотоодод дуурсгасан хийсэн бүтээсэн зүйл ихтэй алдар гавьяатнууд хэдийнээ болжээ. Тэдний нэг болох миний багш профессор, биологийн ухааны доктор А.Пэрлээ нь дэлхийн XXI зууны эрдэмтийннэг, палеонтологийн шинжлэх ухаанд дэлхийд өөрийн мөрөө үлдээсэн нэгэн.

А.Пэрлээ багш маань 1992 оноос МУИС-ийн Геологийн салбарт багшилж эхэлснээр ирээдүйн геологч мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэхэд өөрийн хувь нэмрийг оруулж явна. Ингээд залуу эрдэмтэн багш, судлаач нарт ахмад багш нарын маань амьдрал, судалгаа шинжилгээний ажлын туршлагасаа хуваалцана уу гэж профессор А.Пэрлээтэй багштай түүний судалгаа шинжилгээ, амьдралын замналын тухай бяцхан яриа өрнүүлсэн юм.

Багшаа та ямар сургуульд сурч төгссөн бэ?

Би 1968 онд МУИС-ийн геологийн анги төгссөн. Миний унаган мэргэжил бол зураглалын геологич харин 1965 оноос 1967 оны хооронд МУИС-ийн ректор Д.Цэгмид гуайн тушаалаар 2,5 жилийн англи хэлний орчуулагчийн шуурхай ангид суралцан төгссөн бас нэг үнэмлэхтэй ийм хүндээ багш нь. Харин бүүр хожуу 1981-1983 онд ЗХУ-ын ШУА-ийн Палеонтологийн Хүрээлэнгийн албан тодорхойлолтоор МГУ-ийн Биологийн Факультетэд эртний мөлхөгч амьтны анатоми морфологийн мэргэших чиглэлээр суралцах боломж тохиосон учир тэр сургуулийн диплом ч надад байгаа. Ингэж би геологич, биологич болсны хүчинд хожим 1991 онд ЗХУ-ын ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн болон Северцовын хүрээлэнгийн хамтарсан эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлийн хамтарсан хурлаар Биологийн ухааны доктор болсон билээ.

Ямар чиглэлийн судалгаа хийж докторын зэрэг хамгаалсан бэ?

Багш нь 1970-1982 оныг хүртэл 12-13 жилийн хооронд эрт галавын мөлхөгч амьтан болох динозаврын 17 төрөл амьтны ясан биеийн морфологи хөгжил, өсөлтийн төрөл амьтны ясан биеийн морфологийн адармаат өөрчлөлт, эр эмийн ялгаа, тэдний ангиллын дээд түвшний судалгааг хийж байлаа. Сүүлд эргээд бодоход дээрхи чиглэлийн судалгаа маань тус бүрдээ шинжлэх ухааны докторын төвшиний ажлууд байх юм. Даанч надад тэр үедээ тийм ухаан төрөөгүй юм зүгээр л судлаад хэвлүүлээд байхыг хичээдэг байсан юм. Энэ жилүүдэд би динозавр судлалын ухаанд 3 овог 5 зүйл амьтныг шинээр нээж дэлхийн өндөр зэрэглэлийн

шинжлэх ухааны хэвлэлүүдэд (Орос, Польш Америкийн болон Монголын шинжлэх ухааны Академийн итлгэлүүдэд) нийтлүүлжээ.

Харин 1984 оноос эхлэн ангилал, морфологийн судалгаагаа анатоми, функцийн анатомийн асуудлаар улам баяжуулж гүнзгийрүүлэн судалж ухаанаа төвлөрүүлэн галзууртлаа зүтгэсний хүчинд ажлаа дуусгасан юм. Энэ үед л Английн "Nature", Америкийн "Science", "Scientific America", "Vertebrate Paleontology" зэрэг шинжлэх ухааны оргил хэвлэлүүдэд бүтээлээ гаргаж чадсан юм. Энэ он жилүүдэд л Segnosaurus, Ericosaurus, Enigmosaurus, Goyosephale, Harpumimus зэрэг төрлүүд болон тэдний дээд төвшний ангиллын судалгааг хийж дуусгасан байна. Мөн жилүүдэд би шинжлэх ухаанд анх удаа "Omnivora" холимог идэшт махчин динозаврын бүлгийн судалгааг Монголын олдвор дээр судлан дэвшүүлсэн нь 1980 оны эхний жилүүдэд миний нэрийг шинжлэх ухаанд алдаршуулсан нэг ёсны миний өмч болсон бүтээлүүд юм.

Mononykus нь үнэхээр таны шинжлэх ухааны нээлт мөн үү?

Моно-ганц (нэг) грек хэлээр , nykus-хумс эртний лать хэлээр хумс энэ хоёрыг нийлүүлж би уг амьтныг дэлхийн шинжлэх ухаанд нэрлэсэн билээ. Энэ олдвор бол жижиг махчин динозаврын манирапторын төрлийн динозавраас үүссэн шувуу байлаа. Гэхдээ энэ манираптор гэдэг шувуу маань нисдэггүй газраар гүйж явдаг шувуу байжээ. Үүнийг баталсан бүтээлээ би хоёр америк эрдэмтний хамт М.Норел, Ж.Кларк, Л.Чиапп нарын хамт би нэгдүгээр зохиогч болж английн "Nature" дэлхийн байгаль судлалын сэтгүүл буюу зөвхөн шинжлэх ухааны онолын нээлт хэвлэдэг сэтгүүлд 1993, 1994 онуудад хэвлүүлсэн болно. Энэ бол миний оюун ухааны оргил үе байсан байх ингэж би 1908 онд анх германы эрдэмтэн Хейлман анх архейптерикс бол орчин үеийн шувууг төрүүлсэн тэгэхдээ нисдэг шувууны өвөг элэнц байжээ гэсэн онолыг Пэрлээ би 1993-1994 онд мөн манираптор хэмээх бүлэг динозавраар нисдэггүй шувуу үүссэн болохыг баталсан бүтээлээ хэвлүүлсэн юм даа.

Энэ бол миний 1993 онд хийсэн ажил болно. Мөн 1994 ондоо Nature байгаль шинжлэлийн зөвхөн шинжлэх ухааны нээлт хэвлэдэг сэтгүүлд Mononykus гэдэг амьтны ясан биеийн морфологийн судалж дэлгэрэнгүй бичиглэлийг Америк, Аргентиний 3 эрдэмтэн судлаачийн хамт би өөрөө 1-р зохиогчоор ажиллан хэвлүүлсэн билээ.

Багшаа та манай улсаас анх удаа 1984-1985 онуудад Япон улсад Японы гадаад орнуудтай соёлоор харилцах нийгэмлэгийн шугамаар тэнд явж динозаврын анхны үзэсгэлэн ажиллуулахад 2 жилийн хугацаагаар оролцож ажиллаж байсан тухай ном хэвлэлээр уншиж байсан юм. Тэнд юу хийж байсан тухайгаа яриач?

Би япон орны талаар бага зэрэг гадарлана. Тэнд яаж ажиллаж юу хийж байсан талаар надад одоо нүдэнд минь харагдах дурсамж, авсан фото зураг юм юм байгаа. Тэр цагаас хойш 25 жил өнгөрчээ. Юуны түрүүнд Япон орны тухай надад үлгэрийн сайхан нутаг байлаа. Япон хүний сэтгэл, ямар нэгэн шунал, ховдог санаагүй ард түмэн, найз нөхөртөө хязгааргүй үнэнч сэтгэл тэнд л байна гэж хэлэх байна. Япон улсад би ганцаараа удаан хугацаагаар олон сарын турш ажиллаж амьдрахдаа нийтдээ 62 удаа лекц, яриа хийж монгол орныхоо амьдрал зан үйл, амьдралын хэв маяг, Монгол орны байгаль цаг уур, шинжлэх ухааны

хөгжил, мөнгө төгрөг, цалин пүнлүү, шашин суурь соёлын тухай юу эс сонирхох билээ. Тэр бүгдийн тухай: Гүнма перфектурээс эхлээд Хирошима, Наруто, Киото, Шимиз, Токио, Шизоука нийт японы 22 хотод байгалийн түүх судлалын музей, Японы олон их дээд сургууль зарим үед бага сургууль хүртэл намайг урин лекц, яриа хийлгэж байсан юм. Түүнчилэн 8 сарын турш буудалдаа орой амарч байх үед ч хүртэл үргэлж факсаар асуулт тавьж хариулт авч байлаа. Надтай хамт үргэлж англи хэлний орчуулагч эрэгтэй эмэгтэй хоёр хүн ээлжээр надад үйлчилсэн ба хамт амьдарсан. Энэ бүх зардлыг Япон улсын гадаад орнуудтай соёлоор харилцах нийгэмлэг бид гурвыг цалинжуулж байсан юм. Тэднийхээ цалинг мэдэхгүй харин миний цалин 270.000 иен байсан билээ.

Та зөвхөн шинжлэх ухаанд хийсэн бүтээлээ ярьлаа. Энэ их ажлын хажуугаар амьдралаа хэрхэн авч явж байв даа?

Би эхнэртэйгээ амьдраад одоо 39 жил болох гэж байна. 1972 оны 4 сарын 7 ны баасан гаригт 18 цагт Москвагийн Украин ресторанд бид манай гэргийн найз оюутнууд орос, куб, финлянд, герман улсаас орост сурч байсан Москва хотын Губкиний нэрэмжит нефть хими, хийн үйлдвэрийн дээд сургуулийн 3-р курсын оюутнуудтай хамт манай томилолторр ажиллаж байсан ЗХУ-ын ШУА-ийн Геологийн хүрээлэнгийн болон Палеонтологийн хүрээлэнгийн ажилтнууд 14 хүнтэй хамт нийт 68 хуримын зочинтой хурим хийж билээ.

Тэр цагаас хойш 39 жил өнгөрчээ. Энэ олон жилд бид хоёр 4 хүү нэг охин төрүүлж энх тунх өсгөсөн билээ. Бидний анхны хүү П.Чинболд маань Москва хотын Кларацеткиний нэрэмжит 11-р төрөхөд 1974 оны 6 сарын 5-нд төрсөн билээ. Тэр өдөр би Дэлхийн палеонтологичдийн 1-р их хуралд оролцож байв. Дараагийн 3 хүү Мөнболд, Өнөболд, Эрболд охин Наранчимэг нар маань УБТЗ-ийн төрөх газарт төрсөн.

Миний гэргий Ц.Алтанцэцэг 1974 онд ЗХУ-ын Москва хотод Губкиний нефтийн Академи төгсөж ирээд 1975 оны 2 сарын 15 наас багшилж эхэлснээс өдгөө 35 жилийн нүүр үзэж байна. Энэ хугацаанд Нефтийн салбартаа Монгол улсын зөвлөх инженер, Газрын тосны болоод Нефтийн салбарын тэргүүний ажилтан, Монгол улсын ардын боловсролын тэргүүний ажилтан, Соёл боловсролын эрдмийн цагаан лавай тэмдэгтэн, Монгол улсын нефтийн дунд дээд боловсролтой ажилтан инженер техникчдийн багшийн багш хүн юм. Одоо ШУТИС-д багшилж ар гэр амьдралаа гэргийн ёсоор авч явна.

Таны хамгийн анхны судалгаа шинжилгээний ажил тань ямар ажил байв, ямар экспедицид ажиллаж судалгааны ажлаа эхэлж байсан тухайгаа яриач?

Он жилүүдийн урсгал дунд би палеонтологийн шинжлэх ухааны салбарт ажиллахдаа эхлээд Монгол Польшийн Палеонтологийн хамтарсан экспедицид 1970-1971 онуудад Польш нөхөдтэйгээ ажиллаж явлаа. Тэр жилүүдэд Польшийн шинжлэх ухааны академийн 1-р зэргийн Академич Зофия Киелан Яворовска даргатай 12 польш палеонтологичтой хамтдаа Монголын талаас 3 монгол, манай жолооч Д.Сайнбилэг, лаборант Л.Самбуу, препараторчин А.Пэрлээ бид гурав Монголын Палеонтологичдийг төлөөлж ажилласан юм. 1971 оны хавар Польш нөхөд маань эрт хээрийн судалгаанд гарлаа. Ингэж 1971 оны 6 сарын 24 -нд Зоргол Хайрхан уулын хадах энгэрт майхан тавилгүй хад чулуун дунд гадаа хонож билээ. Тэгэхэд польшуудтай урьд жил нь 2 сар хамт ажилласан, нэлээд танимгай бид

ч бас ч найзархан танил дасал болсон нөхдүүд бид гуравтай уулзсан юм. Ингэж 1971 оны 8 сарын 12-нд ноцолдож байгаад нэгэн зэрэг үхсэн динозаврын араг ясыг олсон билээ.

Тэр зун Монгол-Польшийн палеонтологичид 14 хоног Өмнөговь аймгийн Булган (Баянзагт) хайгуулын маршрут хийгээд цааш хөдөлж Алтай чанад дахь говь лугаа Нэмэгт, Алтан Уул, Цагаан хошуу, Наранбулагт 42 хоног эрэл хайгуул хийсэн билээ. Энд бид хоёр аварга махчин динозаврын бүрэн бус араг яс хоёр нугас хушуут динозаврын хагас араг ясны үлдэгдэл гурван жижиг махчин динозаврын бүтэн хагас араг ясны үлдэгдэл малтаж хайрцаглаж авснаар тэр жилийн хээрийн судалгааны ажлаа дуусгаж 1971 оны 7 сарын 30 нд Улаанбаатар хотын зүг эргэв.

Төгрөгийн ширээгээс (Өмнөговь аймгийн Булган сумын нутаг) 70 сая жилийн өмнө хоорондоо барьцалдан зууралдаж ноцолдсон байдлаар чулуужин хадгалагдсан өвсөн тэжээлт Protoceratops, жижиг махчин Veloceraptor хоёр динозаврын бүтэн араг ясыг та анх олсон юм уу, польшууд олсон юм уу?

Анх энэ олдворын тухай, өөрөө олсныг минь батлах гэсэн юм шиг анх англи хэлээр “Монголиа” сэтгүүлийн англи дугаарт 1973 оны 11 сард “Eighty million years in Mortal Combat” гэсэн өгүүлэл бичиж гаргасан байдаг. Харин 1975 онд польшийн академич Zoria Kielan Jaworowska “Science” сэтгүүлд, академич Р.Барсболд гуай оросын “Природа” сэтгүүлд 1976 онд “Поедимок динозавров” гэсэн өгүүлэл бичсэн юм.

1998 онд Английн Бристолийн их сургуулийн профессор Давид Анвин, М.Труман бид гурав барьцалдан зуурч үхээд хамтдаа 70 сая жилийн турш хөрсөн доор чулуужин хэвтэх динозавруудын палеоэкологийн асуудлыг хөндсөн нэгэн өгүүллийг америкийн “Vertebrate paleontology” сэтгүүлд хэвлүүлсэн билээ. Энэ хавар дэлхийд ганцхан тохиолдлоор олдсон олдвор маань “ШАНХАЙ ЭКСПО-2010” үзэсгэлэнд Монгол улсын павилеоны голд хүний нүд хужирлан байгаа гэж дуулсан.

Таны эдгээр судалгааны ажлын эцсийн үр дүн юу байсан гэж боддог вэ?

Сээр нуруутан амьтдын палеонтологийн судалгаа ялангуяа эртний сээр нуруутан амьтдын харьцуулах морфологийн судалгааны үр дүнд нэгд : амьтны аймгийн тухайн бүлгийн хувьд нэгэн биеийн хөгжлийн явц (онтогенез), хоёрд: эр эм амьтны ялгаа болон бэлгийн шалгарлын хоёр дахь шинж (половой диаморфизм) гуравт: хөгжлийн темп (адаптаци-морфогенез)- хурд энэ гурван асуудлыг онолын хувьд сайн боловсруулж эцсийн үр дүнг гарган тэр нь геологийн шинжлэх ухаанд геологийн орчин тодорхойлох боломж олгодог бол харин биологийн шинжлэх ухааны үндсэн бүхий л асуудал энэ гурав дээр тулгуурлана. Энэ ажлыг хийх гэж зорисон гэж боддог доо.

Багшаа таны ажлууд динозавр судлалын морфогенезын ямар асуудалд хариулт өгсөн бэ?

Холимог тэжээлт Omnivorous амьтны онцлогийг тодорхойлсон тэдний ууц, хойт хөлний өвөрмөц шинжийг тодорхойлон тогтоож мөлхөгч амьтны сүүжний ясны Альтилийн (Altiliac) бүтцийг 1985 онд Р.Барсболдын хамт хийсэн. Үүнээс өмнө 1964 онд Америк эрдэмтэн Эдвин Колберт Врахиоили, Долихоили-г ялган

тодорхойлсон байдаг. Ингэж динозавр судлалын түүхэнд хоол тэжээлийн байдлаар динозавруудыг өвсөн тэжээлт-Herbivorous, махан идэшт - Carnivorous., холимог идэштэн Omnivorous amphibiont – Segnosaurus гэсэн 3 бүлэгт ялгах хамгийн дээд төвшний судалгааг хийсэн юм.Энэ ажлууд бол миний эртний мөлхөгч амьтдын морфогенез хөгжлийн асуудалд оруулсан хувь нэмэр гэж ойлгогддог.

Та Байгалийн Түүхийн Музейн захирлаар ажиллаж байсан тухайгаа дурсаач?

Монгол улсын Байгалийн Түүхийн Музей 1991 оны 8-р сарын сүүлчээр Улсын төв музей татан буугдахад түүний орон дээр “Монгол Улсын Байгалийн түүхийн музей” нэртэйгээр шинээр музей байгуулах их ажлыг хариуцуулж ШУА-иас намайг томилсон юм.

Байгалийн түүхийн музей байгуулах улсын төлөвлөгөөний дагуу хамгийн эхлээд хүн судлалын асуудлаар Музейн зураач МУСГЗ Нанзадсүрэнгийн зурсан том зурагны ерөнхий агуулгыг гаргасан Диорамм хийх ажилд орлоо. Энэ хэсгийг хагас жилд багтааж хийсэн бөгөөд 1992 оны 1-р сараас Хөхтөн амьтадын хөгжлийн бүтэц зохион байгуулалтыг үзүүлсэн макет, хиймэл хэв бүтээх ажлыг 3 сард хийж дуусгасан байна. 1992 оны 3-р сараас 6-р сарын нэгэн хүртэл 3-р давхрын шувууны хэсгийг байгуулах Тогосын диораммны гэрэлтүүлэг хийх ажлыг Цогтбаяр, Цэрэндолгор нар хариуцан бүрэн бүтээх, мөн энэ давхарт хандгай болон бугын диорамм босгох ажлыг хийсэн билээ. 1992 оны 3, 4-р улиралд П.Эрдэнэбат нар цагаан зээрийн диорамм байгуулах, аргаль, янгирын диораммуудыг байгуулав. 1993 оны туршид Ж.Цогтбаяр хариуцаж Говь, Тал хээр, Саваннын диораммуудыг байгуулсан байна. Харин Байгалийн Түүхийн Музейн доод 1-р давхрын хойт жигүүрийн шувуунууд л яг тэр чигээрээ өдийг хүрсэн билээ.

Мөн энд ирвэс, ойн жирэм, баавгай зэрэг диораммуудад хүний гар хүрээгүй өдий хүрлээ.

Музейн бусад үзмэрүүдийг: Дагиймаа, Баасансүх нар хариуцан чонын гөлөгнүүд, цаа буга, жирх, хүдэр, буга, гахай тэргүүтнүүдэд тусгай жижиг диораммуудыг 1994 оны эхэн хагаст хийж босгосон. Мөн ургамлын хэсгийг Ч.Дулмаа хариуцан хийсэн билээ. Байгалийн Түүхийн Музей байгуулахад Цэвэл, Нанзадсүрэн, Содном, Жаргалсайхан, Цэрэндолгор, Цогтбаяр, Мөнхжаргал, Баранзад, Отгонжаргал, Дулмаа, Байгалмаа, Отгон, Эрдэнэбат, Дагиймаа, Цэдэндолгор зэрэг нөхөд минь надтай гар, сэтгэл нийлж хичээн зүтгэж байсанд баярлаж талархаж явдаг даа. Энэ бол бидний амьдралын нэгэн дургалт он жилүүд байж дээ.

За баярлалаа багшаа таньд эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж ойн баярын мэнд хүргэе.

проф А.Пэрлээгийн хийсэн шинжлэх ухааны ажилтай холбоотой олон улсын шинжлэх ухааны хэвлэлүүдэд хэвлэгдсэн бүтээлийн жагсаалт:

1. Perle.A, 1973, "80 million years in Mortal Combat Mongolia" 1973.10 p.29-30
2. Перлэ.А, 1977. О первой находке Алектрозавра из верхнего мела. "Проблемы монголии" ШУА. х. 1.0 печ.лист
3. Перлэ.А, 1979 Сегнозаврид – новое семейство мела терепода из позднего мела Монголии. Москва.Наука 1.5 печ.лист
4. Перлэ.А, 1979 Модификации таза заурисхий и параллельная эволюция хищных динозавров.Москва.наука 1,0 печ.лист

5. Perle, A., Segnosauria a new infraorder of carnivorous dinosaurs. Act paleontol. Polonica Warszawa 1,5 p.p
6. Перлэ, А., 1981 Новый сегнозаврид из верхнего мела Монголии. В кн: ископаемые позвоночные Монголии. Тр. ССМПЭ, вып. 15. М., Наука, 1981, 50-59
7. Перлэ, А., 1982 О находке задней конечности теризинозавра из верхнего мела Монголии. Тр. ГИН АН МНР вып 5, с 94-99
8. Перлэ, А., 1983 К вопросу о происхождении птиц. вэстн. АН МНР №2, с.20-24
9. Perle, A., 1993 Flightless bird from the upper cretaceous of Mongolia. Nature. Vol 623-628
10. Perle, A., The skeletal morphology mononykus olecranus (Theropodus Avalae) from the late cretaceous of Mongolia. American Museum Novitates New York Nu 309 2.0 pp
11. Perle, A., 1995 The phylogenetic relationships of Segnosaur Theropod
12. Perle, A., 1995 Extraordinary preservation in a new vertebrate assemblage. NATURE Vol.374, p.446-449 London UK
13. Perle, A., 1995 Theropod dinosaur embryo and affinities of the flaming cliffs dinosaurs eggs. Science vol.166, p.712-740
14. Perle, A., 1996 The morphological and Locomotoral peculiarities of the saurichian dinosaurs-pelvic structure. Special papers to the 30 th international Geological Congress. Problems of geology and mineral resources of Mongolia. p 13-15
15. Perle, A., 1997 On the origin bird flight. Ховд хот Баруун Монголын байгалийн ресурс олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүд
16. Perle, A., 1998 The primitive models of the pelvic and limb structures muscle of reptiles (lizard, crocodiles and bird). ШУТИС ийн бүтээл
17. Perle, A., 1999 Morphology of Achillobator from the upper cretaceous of Burkhan formation of Mongolia. National University press. p.96
18. Перлэ, А., Динозавр нисдэггүй шувууны хөгжлийн эхэнд байсан нь. МУ-ын ШУА. Геологийн хүрээлэнгийн бүтээл. №13. х.75-80